

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

201... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

### НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь нийгмийн халамжид хамрагдах иргэдийн амьдралын наад захын хэрэгцээг хангах, тэднийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамруулах замаар ядуурлаас гарахад нь дэмжлэг үзүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлж, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусlamж, хөнгөлөлт, үйлчилгээний төрөл, хамрах хүрээг тогтоох, нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо, чиг үүргийг тодорхойлох, нийгмийн халамжийн сан бүрдүүлэх, уг сангийн хөрөнгийг зарцуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл.Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомж

2.1. Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрднө.

##### 3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. “нийгмийн халамж” гэж энэ хуулийн 3.1.2-т заасан өрх, иргэний амьдралын наад захын хэрэгцээг хангах зорилгоор төрөөс тэтгэвэр, тэтгэмж олгох, тусlamж, хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх нийгэм, эдийн засгийн арга хэмжээг;

3.1.2. “зорилтот өрх, иргэн” гэж ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, өрх толгойлсон эх, эцэг, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, байнгын асаргаа шаардлагатай хүн, байгалийн болон нийтийг хамарсан гамшиг, аюулт үзэгдлийн улмаас орон гэргүй болсон өрх, орон гэргүй, тэнэмэл амьдралтай иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг;

3.1.3. “нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэн” гэж Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хамтран баталсан

<sup>1</sup>Монгол Улсын Үндсэн хууль -“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

аргачлалын дагуу тогтоосон амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогур байгаа өрх, иргэнийг;

3.1.4.“эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэж Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэгт заасан хүүхдийг<sup>2</sup>;

3.1.5.“ахмад настан” гэж Ахмад настны тухай хуулийн<sup>3</sup> З дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасан хүнийг;

3.1.6.“хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэж Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн<sup>4</sup> 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэгт заасан хүнийг;

3.1.7.“байнгын асаргаа шаардлагатай хүн” гэж өвчин, осол гэмтлийн улмаас 6 ба түүнээс дээш сарын хугацаагаар өөрөө өөртөө үйлчлэх чадваргүй болсныг эсхүл оюуны хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэйг нь эрх бүхий байгууллагаас тогтоосон хүнийг;

3.1.8.“бүтэн өнчин хүүхэд” гэж эцэг, эх нь тогтоогдоогүй, эсхүл эцэг, эх нь хоёул нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, түүнчлэн эцэг тодорхойгүйн улмаас эхтэйгээ амьдарч байгаад эх нь нас барсан, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийг;

3.1.9.“өрх толгойлсон эх /эцэг/” гэж нөхөр, эхнэрийн аль нэг нь нас барсан, эсхүл сураггүй алга болсон нь шүүхээр тогтоогдсон, гэрлэлтээ цуцлуулсан, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, гэрлэж байгаагүй боловч төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэдтэй ганц бие эх /эцэг/-ийг;

3.1.10.“төрөлжсөн асрамжийн үйлчилгээ” гэж асран хамгаалах, харгалзан дэмжих төрөл, садангүй бөгөөд бие даан амьдрах чадваргүй, ганц бие, байнгын асаргаа шаардлагатай хүн, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг байрлуулан хоол, хувцас, соёл, ахуйн наад захын хэрэгслээр хангах, сэтгэл зүй, асаргаа сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлэх замаар тэдний амьдрах хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, хууль тогтоомжид заасны дагуу хууль ёсны эрх ашгийг нь хамгаалах арга хэмжээг;

3.1.11.“олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ” гэж иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор зорилтот өрх, иргэнд үзүүлэх үйлчилгээг;

3.1.12.“босго оноо” гэж энэ хуулийн 44.1.2-д заасан Өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдэж, амьжиргааны түвшин нь үнэлэгдсэн өрхөөс нийгмийн халамжийн тухайн арга хэмжээнд хамрагдах зорилтот өрх, иргэнийг тогтоох зорилгоор нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тогтоосон онооны хязгаарыг;

<sup>2</sup>Хүүхэд хамгааллын тухай хууль –“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2012 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

<sup>3</sup>Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль –“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2017 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

<sup>4</sup>Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль –“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2006 оны 4 дугаарт нийтлэгдсэн.

3.1.13.“ядуурлын шугам” гэж Үндэсний статистикийн хорооноос өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаанд үндэслэн нэг хүний сарын амьжирааны доод түвшинг тодорхойлсон мөнгөн дүн.

#### **4 дүгээр зүйл.Нийгмийн халамжийн хамрах хүрээ**

4.1.Нийгмийн халамжийн арга хэмжээнд энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан болзол, нөхцөлийг хангасан Монгол Улсын иргэн хамрагдана.

4.2.Хуульд заасны дагуу Монгол Улсад оршин суух зөвшөөрөл бүхий гадаадын иргэн, харьяалалгүй хүн хамрагдаж болно.

#### **5 дугаар зүйл.Нийгмийн халамжийн үйл ажиллагаанд баримтлах зарчим**

5.1.Нийгмийн халамжийн үйл ажиллагаанд дараахь зарчмыг баримтална:

5.1.1.хүний эрх, эрхэм чанар, хууль ёсны ашиг сонирхлыг дээдлэх;

5.1.2.хүнлэг, энэрэнгүй байдлыг эрхэмлэх;

5.1.3.зорилтот өрх, иргэний хэрэгцээнд тулгуурласан байх;

5.1.4.өрх, иргэний амьдралын чанарт эерэг өөрчлөлт гаражад чиглэгдсэн байх;

5.1.5.зорилтот өрх, иргэнийг чадваржуулах, нийгмийн амьдралд оролцох оролцоог дээшлүүлэх, түүнд багтаахад чиглэсэн байх;

5.1.6.шуурхай, хариуцлагатай, хуульд заасан нууцад хамаарахаас бусад нь ил тод, нээлттэй байх.

#### **6 дугаар зүйл.Нийгмийн халамжийн арга хэмжээний төрөл**

6.1.Нийгмийн халамжийн арга хэмжээ нь дараахь төрөлтэй байна:

6.1.1.нийгмийн халамжийн тэтгэвэр;

6.1.2.нийгмийн халамжийн тэтгэмж;

6.1.3.нийгмийн халамжийн тусламж, хөнгөлөлт;

6.1.4.нийгмийн халамжийн үйлчилгээ.

### **ХОЁРДУГААР БҮЛЭГ НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ**

#### **7 дугаар зүйл.Нийгмийн халамжийн тэтгэвэр**

7.1.Нийгмийн халамжийн тэтгэвэр /цаашид “тэтгэвэр” гэх/-ийг нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасны дагуу тэтгэвэр авах эрх үүсээгүй дараахь иргэнд сар бүр олгоно:

7.1.1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгох насандаа хүрсэн иргэн;

7.1.2.хөдөлмөрийн чадвараа 50-69 хувиар алдсан 16 насандаа хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн;

7.1.3.хөдөлмөрийн чадвараа 70 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насандаа хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн;

7.1.4.16 насандаа хүрсэн одой иргэн;

7.1.5.тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насын хүүхэд;

7.1.6.байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэх боломжгүй эх, эцэг;

7.1.7.18 хүртэлх насын гурав болон түүнээс дээш хүүхэдтэй, энэ хуулийн 3.1.3-д заасан өрх толгойлсон эх, эцэг.

## **8 дугаар зүйл.Нийгмийн халамжийн тэтгэмж**

8.1.Нийгмийн халамжийн тэтгэмж /цаашид “тэтгэмж” гэх/ дараахь төрөлтэй байна:

8.1.1.асаргааны тэтгэмж;

8.1.2.ядуу өрхийн тэтгэмж;

8.2.Асаргааны тэтгэмжийг байнгын асаргаа шаардлагатай дараахь иргэнд сар бүр олгоно:

8.2.1.байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насын хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд;

8.2.2.байнгын асаргаа шаардлагатай 16 болон түүнээс дээш насын хөгжлийн бэрхшээлтэй иргэн;

8.2.3.байнгын асаргаа шаардлагатай ахмад настан.

8.3.Энэ хуулийн 3.1.12-д заасан босго онооноос доогуур амьжиргаатай өрхийн иргэн бүрд ядуу өрхийн тэтгэмжийг сар бүр олгоно.

## **9 дүгээр зүйл.Тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ, журам**

9.1.Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг тухайн үеийн хүн амын амьжиргааны доод түвшингийн бүсүүдийн дунджаас багагүй байхаар Засгийн газар тогтооно.

9.2.Энэ хуулийн 7.1.1-д заасан иргэнд олгох тэтгэврийн хэмжээ нь мөн хуулийн 46.1.2-д заасан Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэлд үндэслэн тогтоосон өрхийн амьжиргааны түвшиний үнэлгээнээс хамаарч ялгаатай байна.

9.3.Энэ хуулийн 7.1.5-т заасан тэтгэврийг тэжээгч нь нас барсан өрхийн 2 хүртэлх хүүхдэд нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээгээр, 4 хүртэлх хүүхдэд нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 1.5 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр, 5 болон түүнээс дээш хүүхдэд 2 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр тооцож олгоно.

9.4.Энэ хуулийн 7.1-д заасан тэтгэврийг давхардуулан авах нөхцөл үүссэн тохиолдолд иргэнд зөвхөн нэг нөхцлөөр тэтгэврийг олгоно.

9.5.Энэ хуулийн 8.2.1-д заасан тэтгэмжийн хэмжээ нь мөн хуулийн 9.1-д заасан тэтгэврийн хэмжээтэй тэнцүү байна.

9.6.Энэ хуулийн 8.1.2, 8.2.2, 8.2.3-д заасан тэтгэмжийн хэмжээг хэрэглээний үнийн индекстэй уялдуулан Засгийн газар тогтооно.

9.7.Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох журмыг Засгийн газар батална.

9.8. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох журамд хугацаа, хөдөлмөр эрхлэлтийн болон боловсрол, эрүүл мэндийн суурь үйлчилгээнд хамрагдсан байх, зан үлийн эерэг өөрчлөлт бий болсон байх зэрэг нөхцөл, шалгуурыг тусгасан байна.

9.9. Энэ хуулийн 8.2.1-8.2.3-т заасан иргэний байнгын асаргаа шаардлагатайг тодорхойлох өвчин, гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлт, зааврыг эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

## **10 дугаар зүйл. Тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох өргөдөл гарах, шийдвэрлэх хугацаа**

10.1. Тэтгэвэр, тэтгэмж тогтоолгон авахыг хүссэн иргэн холбогдох баримт бичгийг бүрдүүлж, өргөдлийн маягтын хамт сум, хорооны нийгмийн ажилтанд өгнө.

10.2. Сум, хорооны нийгмийн ажилтан энэ хуулийн 10.1-д заасан баримт бичгийг хүлээж авснаас хойш 30 хүртэл хоногийн дотор хянан шийдвэрлүүлнэ.

10.3. Тэтгэвэр, тэтгэмж авах иргэний өргөдөл, хувийн хэрэг болон бусад маягтын загварыг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

## **11 дүгээр зүйл. Тэтгэвэр, тэтгэмж олголт**

11.1. Нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага тэтгэвэр, тэтгэмжийг банкаар дамжуулан олгоно.

11.2. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрийн биеэр ирж тэтгэвэр, тэтгэмжээ авах боломжгүй иргэний тэтгэвэр, тэтгэмжийг Нотариатын тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасан итгэмжлэгдсэн хүнд олгоно. Суманд нотариатч ажиллаагүй тохиолдолд Нотариатын тухай хуулийн 10.2-т заасныг баримтална.

11.3. 16 хүртэлх насын хүүхдэд олгох тэтгэвэр, тэтгэмжийг эцэг, эх, эсхүл хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нь олгоно.

11.4. Иргэнд тэтгэвэр, тэтгэмжийг баримт бичиг нь бүрдэж, өргөдөл гаргасан өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх, хуулиар тогтоосон бусад эрх нь дуусгавар болох хүртэлх хугацаанд олгоно.

11.5. Тэтгэвэр, тэтгэмж авагч наас барсан тохиолдолд тэтгэвэр, тэтгэмжийг түүний наас барсан сар, наас барсны дараагийн сарын тэтгэвэр, тэтгэмжийг гэр булийн гишүүн, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нь бүрэн олгоно.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУСЛАМЖ, ХӨНГӨЛӨЛТ**

## **12 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тусlamж, хөнгөлөлт**

12.1. Нийгмийн халамжийн туссламж, хөнгөлөлт нь дараахь төрөлтэй байна:

- 12.1.1.амьжиргааны тусламж;
- 12.1.2.хүнс тэжээлийн тусламж;
- 12.1.3.сурагчийн дүрэмт хувцасны үнийн хөнгөлөлт;
- 12.1.4.эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт;
- 12.1.5.Ахмад настны тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлэхээр заасан бусад тусламж, хөнгөлөлт.

### **13 дугаар зүйл.Амьжиргааны тусламж**

13.1.Амьжиргааны тусламжийг дараахь өрх, иргэнд үзүүлнэ.

- 13.1.1.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг хууль ёсны дагуу асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа өрх;
- 13.1.2.тэжээн тэтгэх хүүхэдгүй, бие даан амьдрах чадваргүй ганц бие ахмад настаныг гэр бүлдээ авч асрамжилж байгаа өрх;
- 13.1.3.тэжээн тэтгэх хүүхэдгүй, бие даан амьдрах чадваргүй ганц бие хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа өрх;
- 13.1.4.байгалийн болон нийтийг хамарсан гамшиг, аюулт үзэгдлийн улмаас орон гэргүй болсон өрх;
- 13.1.5.18 нас хүрээгүй байхдаа бутэн өнчин болсон 18-24 насны иргэн;
- 13.1.6.энэ хуулийн 17.1.1-д заасан үйлчилгээнд хамрагдаж, бие даан амьдрах хүсэл, чадвартай болсон орон гэргүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн.

13.2.Амьжиргааны тусламжийг энэ хуулийн 13.1.1-13.1.3-д заасан өрхөд улиралд нэг удаа, 13.1.4-13.1.6-д заасан өрх, иргэнд нэг удаа тус тус олгоно.

13.3.Энэ хуулийн 13.1.6-д заасан өрх, иргэнд амьжиргааны тусламжийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдах нөхцөлтэйгөөр олгоно.

13.4.Амьжиргааны тусламжийн хэмжээ, нөхцөл шалгуур, олгох журмыг Засгийн газар батална.

### **14 дүгээр зүйл.Хүнс тэжээлийн тусламж**

14.1.Хүнс тэжээлийн тусламжийг энэ хуулийн 3.1.12-д заасан босго онооноос доогуур амьжиргаатай өрхийн иргэнд сар бүр олгоно.

14.2.Хүнс тэжээлийн тусламж нь хүнсний бүтээгдэхүүн худалдан авах эрхийн бичиг хэлбэр /цаасан эсхүл цахим/-тэй байна.

14.3.Энэ хуулийн 13.1.4-д заасан өрхөд хүнс тэжээлийн тусламжийг гамшигийн хор уршгийг арилгах хүртэлх хугацаанд олгож болно.

14.4.Хүнс тэжээлийн тусламж олгох журам, нэг хүнд ногдох зардлын хэмжээ, нөхцөл, хугацааг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

### **15 дугаар зүйл.Сурагчийн дүрэмт хувцасны үнийн хөнгөлөлт**

15.1.Сурагчийн дүрэмт хувцасны үнийн хөнгөлөлтийг энэ хуулийн 3.1.12-т заасан босго онооноос доогуур амьжиргаатай, сургуулийн насны хүүхдээ албан боловсролд хамруулсан өрхийн хүүхэд бүрд олгоно.

15.2.Энэ хуулийн 15.1-д заасан өрхийн хүүхдэд сурагчийн дүрэмт хувцасны үнийн хөнгөлөлтийг 2 жил тутамд нэг удаа олгоно.

15.3.Сурагчийн дүрэмт хувцасны үнийн хөнгөлөлтийн хэмжээ, олгох журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## **16 дугаар зүйл.Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт**

16.1.Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлтөд энэ хуулийн 3.1.3-т заасан өрх, иргэн хамрагдана.

16.2.Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлтийг Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд<sup>5</sup> заасан хувь хэмжээгээр төрөөс бүрэн хариуцна.

### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

## **17 дугаар зүйл.Нийгмийн халамжийн үйлчилгээний төрөл**

17.1.Нийгмийн халамжийн үйлчилгээ нь дараах төрөлтэй байна:

- 17.1.1.нийгмийн халамжийн байгууллагаас үзүүлэх үйлчилгээ;
- 17.1.2.олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ;
- 17.1.3.төрөлжсөн асрамжийн үйлчилгээ.

## **18 дугаар зүйл.Нийгмийн халамжийн байгууллагаас үзүүлэх үйлчилгээ**

18.1.Нийгмийн халамжийн байгууллагаас зорилтот өрх, иргэнд дараах үйлчилгээг үзүүлнэ:

- 18.1.1.зөвлөгөө, мэдээлэл өгөх;
- 18.1.2.өрхийн хөгжлийг дэмжих;
- 18.1.3.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих.

## **19 дүгээр зүйл.Зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээ**

19.1.Сум, хорооны нийгмийн ажилтан нь нийгмийн халамжийн арга хэмжээнд хамрагдах хүсэлтэй өрх, иргэний санал хүсэлтийг сонсох, тэдний хэрэгцээнд нийцсэн боловсрол, эрүүл мэнд, хууль эрх зүй зэрэг тусгайлсан зөвлөгөө, мэдээлэл өгнө.

19.2.Зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагааг ганцаарчилсан болон бүлгийн хэлбэрээр зохион байгуулна.

## **20 дугаар зүйл.Өрхийн хөгжлийг дэмжих үйлчилгээ**

<sup>5</sup>Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль -“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 18 дугаарт нийтлэгдсэн.

20.1.Сум, хорооны нийгмийн ажилтан энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасан үйлчилгээний үр дунд үндэслэн шаардлагатай зорилтот өрх, иргэнд нөхцөл байдлын үнэлгээ хийнэ.

20.2.Энэ хуулийн 20.1-д заасан үнэлгээнд үндэслэн сум, хорооны нийгмийн ажилтан зорилтот өрх, иргэнд шаардлагатай нийгмийн үйлчилгээний багцыг тодорхойлж, өрхийн гишүүнтэй хамтран Өрхийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.

20.3.Өрхийн хөгжлийн төлөвлөгөөнд үндэслэн зорилтот өрх, иргэнийг шаардлагатай нийгмийн халамжийн арга хэмжээнд хамруулж, боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт зэрэг нийгмийн бусад үйлчилгээ, дэмжлэгт холбон зуучилна.

20.4.Энэ хуулийн 20.1-д заасан нөхцөл, байдлын үнэлгээ хийх маягтын загвар, Өрхийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах аргачлал, зааврыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## **21 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ**

21.1.Нийгмийн халамжийн арга хэмжээнд хамрагдаж байгаа хөдөлмөрийн насын, хөдөлмөрийн чадвартай боловч хөдөлмөр эрхлээгүй иргэдийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамруулна.

21.2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд хамрагдсан байдлаас хамаарч иргэний авч байсан тэтгэвэр, тэтгэмж, тусlamж, хөнгөлөлтийг үргэлжлүүлэх, түдгэлзүүлэх, цуцлах шийдвэрийг хууль тогтоомжид заасны дагуу аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллага гаргана.

21.3.Нийгмийн халамжийн арга хэмжээний төрөл, онцлогоос хамаарч энэ хуулийн 21.2-д заасан нөхцөл харилцан адилгүй байна.

## **22 дугаар зүйл.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ**

22.1.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээнд дараах өрх, иргэн хамрагдана:

- 22.1.1.ахмад настан;
- 22.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хүн;
- 22.1.3.өрх толгойлсон эх,эцэг;
- 22.1.4.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд;
- 22.1.5. 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насын иргэн
- 22.1.6.орон гэргүй тэнэмэл амьдралтай иргэн;
- 22.1.7.хорих ангиас суллагдсан иргэн;
- 22.1.8.согтуурах мансуурах донтох өвчтэй иргэн;
- 22.1.9.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрх;
- 22.1.10.энэ хуулийн 3.1.3-д заасан өрх, иргэн.

**22.2.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ нь дараахь төрөлтэй байна:**

- 22.2.1.хувь хүнийг хөгжүүлэх, нийгмийн амьдралд орох оролцоог дэмжих үйлчилгээ;
- 22.2.2.өдрийн үйлчилгээ;
- 22.2.3.гэрийн асрамж, халамжийн үйлчилгээ;
- 22.2.4.орон гэргүй, тэнэмэл амьдралтай иргэдийг түр байрлуулах үйлчилгээ;
- 22.2.5.орлогын эх үүсвэртэй болгоход чиглэсэн төслийг дэмжих үйлчилгээ;
- 22.2.6.орон нутгийн онцлогт тохирсон бусад үйлчилгээ.

**23 дугаар зүйл.Хувь хүнийг хөгжүүлэх, нийгмийн амьдралд орох оролцоог дэмжих үйлчилгээ**

23.1.Зорилтот бүлгийн өрх, иргэний зан үйл, хандлагыг өөрчлөх, бие даан амьдрах чадварыг дээшлүүлэх, нийгмийн гадна үлдэхээс сэргийлэх, зорилгоор хувь хүнийг хөгжүүлэх, нийгмийн амьдралд орох оролцоог дэмжих үйлчилгээ дараахь чиглэлээр үзүүлнэ:

- 23.1.1.зан үйл, хандлагыг өөрчлөх, сэтгэл зүйн тэнцвэртэй байдлыг хадгалах, сэргээхэд чиглэсэн нийгмийн сэтгэл зүйн зөвлөгөөг өгөх;
- 23.1.2.нийгмийн гадна үлдэхээс сэргийлэхэд чиглэсэн соёл, олон нийтийн арга хэмжээг зохион байгуулж, оролцуулах;
- 23.1.3.бие даан амьдрах чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн өөрийгөө үнэлэх үнэлэмж, итгэл үнэмшилтэй болгох, хөгжих, хөдөлмөрлөх хандлагыг төлөвшүүлэх сургалт зохион байгуулах.

23.2.Хувь хүнийг хөгжүүлэх, нийгмийн амьдралд орох оролцоог дэмжих үйлчилгээг зорилтот өрх, иргэний хэрэгцээнд нийцүүлж, ганцаарчилсан болон бүлгийн хэлбэрээр зохион байгуулна.

**24 дүгээр зүйл.Өдрийн үйлчилгээ**

24.1.Ахмад настанд үзүүлэх өдрийн үйлчилгээг Ахмад настны тухай хуулийн 7.1.4-д заасны дагуу зохион байгуулна.

24.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүн, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, ядуурлын шугамаас доогуур байгаа өрхийн хүүхдэд өдрийн үйлчилгээг эрүүл, аюулгүй орчинд хооплох, сургах, хөгжүүлэх хэлбэрээр зохион байгуулна.

**25 дугаар зүйл.Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээ**

25.1.Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээг Ахмад настны тухай хуулийн 7.1.3, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 32.3-д заасны дагуу үзүүлнэ.

**26 дугаар зүйл.Орон гэргүй тэнэмэл амьдралтай иргэнийг түр байршуулах үйлчилгээ**

26.1.Орон гэргүй тэнэмэл амьдралтай иргэнийг түр хоноглох байранд байршуулан хоол, хүнс, ахуйн наад захын хэрэгцээгээр хангаж, бичиг баримтжуулах үйлчилгээ үзүүлнэ.

26.2.Түр байршуулах үйлчилгээнд хамрагдсан иргэнд сэтгэл зүй, сэтгэл заслын зөвлөгөө өгөх, амьдрах итгэлийг нэмэгдүүлэх сургалт, нийгмийн халамжийн болон бусад үйлчилгээнд хамруулна.

26.3.Түр хоноглох байрыг төрийн болон төрийн бус байгууллагын дэргэд аймаг, нийслэл, дүүргийн нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу байгуулан ажиллуулж болно.

## **27 дугаар зүйл.Орлогын эх үүсвэртэй болгоход чиглэсэн төслийг дэмжих үйлчилгээ**

27.1.Энэ хуулийн 22.1-д заасан өрх, иргэн орлогын эх үүсвэртэй болох, амьжиргаагаа дээшлүүлэх зорилгоор хамт олны бүлэг бүрдүүлэн санаачлан хэрэгжүүлэх төсөлд санхүүгийн буцалтгүй дэмжлэг үзүүлнэ.

## **28 дугаар зүйл.Орон нутгийн онцлогт тохирсон бусад үйлчилгээ**

28.1.Энэ хуулийн 42 дугаар зүйлд заасан аймаг, дүүргийн Нийгмийн халамжийн үйлчилгээний зөвлөл нь орон нутгийн онцлогт тохирсон олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн шинэ төрлийн үйлчилгээг санаачлан хэрэгжүүлж болно.

## **29 дүгээр зүйл.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээний зохион байгуулалт**

29.1.Аймаг, дүүргийн Нийгмийн халамжийн зөвлөл нь тухайн орон нутагт олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулна.

29.2.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээний журам, үйлчилгээг үзүүлэх байгууллагад тавигдах шалгуурыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

29.3.Энэ хуулийн 22 дугаар зүйлд заасан үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, зардлыг гэрээний үндсэн дээр орон нутгийн төсвийн хөрөнгөөс санхүүжүүлнэ.

## **30 дугаар зүйл.Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ**

30.1.Төрөлжсөн асрамжийн үйлчилгээг улс, бүс, орон нутгийн асрамжийн газар үзүүлнэ.

30.2.Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ нь дараах төрөлтэй байна:

- 30.2.1.ахмад настны асрамжийн үйлчилгээ;
- 30.2.2.хөгжлийн бэрхшээлтэй иргэний асрамжийн үйлчилгээ;
- 30.2.3.18 хүртэлх насны хүүхдийн асрамжийн үйлчилгээ.

30.3.Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ нь төлбөртэй, төлбөргүй хэлбэртэй байна.

30.4.Төрөөс үзүүлэх төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд дараахь иргэнийг хамруулна:

30.4.1.тэжээн тэтгэх хүүхэдгүй, бие даан амьдрах чадваргүй ганц бие, эсхүл тэжээн тэтгэх хүүхэд нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэйн улмаас дэмжлэг, туслалцаа үзүүлэх чадваргүй, тэжээн тэтгэх үүрэгтэй этгээд нь тухайн ахмад настны эсрэг хүчирхийлэл үйлдсэн болох нь тогтоогдсон;

30.4.2.тэжээн тэтгэх хүүхэдгүй, бие даан амьдрах чадваргүй, мэргэжлийн үйлчилгээ, тусгай нөхцөл шаардлагатай ганц бие хөгжлийн бэрхшээлтэй иргэн;

30.4.3.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд.

30.5.Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь үйлчлүүлэгчтэй хамтран гаргасан асууллагчийн онцлогт нийцэн хувь хүний хөгжлийг дэмжих төлөвлөгөөг асууллагч тус бүрээр гаргана.

30.6.Энэ хуулийн 30.4.1-30.4.3-т заасан хүүхэд болон иргэнийг төрөөс үзүүлэх төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах тухай шийдвэрийг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын саналыг үндэслэн аймаг, дүүргийн Засаг дарга гаргана.

30.7.Төрөөс үзүүлэх төрөлжсөн асрамжийн үйлчилгээний хоол хүнс, хувцас, зөөлөн эдлэл, эм, ариун цэвэр, сургалтын хэрэглэгдэхүүний зардлын хэмжээг санхүү, төсвийн болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

30.8.Төрөлжсөн асрамжийн үйлчилгээний стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

30.9.Энэ хуулийн 30.2.1, 30.2.2-т заасан асрамжийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, 30.2.3-т заасан асрамжийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага олгоно.

30.10.Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, магадлан итгэмжлэх журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

30.11.Төрөөс үзүүлэх төрөлжсөн асрамжийн газрын төсвийг бүрдүүлэх, зарцуулах, үйл ажиллагаанд нь хяналт тавих, асууллагчийг хүлээн авах, шилжүүлэх, гаргах журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

30.12.Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ эрхэлж байгаа байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг энэ хуулийн 38.6-38.8-д заасан байгууллага, ажилтан хэрэгжүүлнэ.

30.13.Төрөөс үзүүлэх төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагч ахмад настан, 18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэврийнх нь 70 хувийг асуулж байгаа асуулагчид олгож, 30 хувийг тухайн асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагад нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу олгоно.

30.14.Иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нь энэ хуулийн 30.3-д заасан хэлбэрээр төрөлжсөн асрамжийн үйлчилгээг үзүүлж болно.

30.15.Төрөлжсөн асрамжийн үйлчилгээг төлбөргүй үзүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг төрөөс дэмжиж энэ хуулийн 30.7-д заасан зардлыг олгоно.

## **ТАВДУГААР БҮЛЭГ НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САН**

### **31 дугээр зүйл.Нийгмийн халамжийн сан**

31.1.Нийгмийн халамжийн сан /цаашид “халамжийн сан” гэх/ нь мөнгөн хөрөнгийн сан байна.

### **32 дугаар зүйл.Халамжийн сангийн орлогын эх үүсвэр**

32.1.Халамжийн сангийн орлого дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

- 32.1.1.улс, орон нутгийн төсвөөс олгох хөрөнгө;
- 32.1.2.олон улсын байгууллага, гадаад улсаас өгсөн хандив, тусlamж;
- 32.1.3.аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн хандив, тусlamж;
- 32.1.4.банкинд байршсан сангийн хөрөнгийн үлдэгдлийн хүү;
- 32.1.5.бусад эх үүсвэр.

32.2.Халамжийн сангийн орлого бүх төрлийн татвар, хураамжаас чөлөөлөгднө.

### **33 дугаар зүйл.Халамжийн сангийн зарцуулалт**

33.1.Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийг дараахь үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулна:

- 33.1.1.нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж;
- 33.1.2.нийгмийн халамжийн тусlamж, хөнгөлөлт;
- 33.1.3.нийгмийн халамжийн үйлчилгээ;
- 33.1.4.шинэ төрлийн үйлчилгээ турших болон хууль тогтоомжийн өөрчлөлтийн улмаас нийгмийн халамжийн арга хэмжээнээс хасагдсан иргэнд үзүүлэх үйлчилгээний зардал;

33.1.5.энэ хуулийн 43 дугаар зүйлд заасан зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдон гарах зайлшгүй зардал, зөвлөлийн гишүүн, сум, хорооны нийгмийн ажилтанд олгох урамшуулал;

33.1.6.нийгмийн ажилтны чадавхийг бэхжүүлэх, мэргэшүүлэх сургалтын зардал;

33.1.7.нийгмийн халамжийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, ажиллуулах, шинэчлэхтэй холбогдсон зардал;

33.1.8.нийгмийн халамжийн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх судалгаа, хяналт-шинжилгээ, үнэлгээний зардал;

33.1.9.холбогдох хууль тогтоомжийн дагуу зөвшөөрсөн бусад арга хэмжээний зардал.

33.2.Халамжийн сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг хориглоно.

### **34 дүгээр зүйл.Халамжийн санд улсын төсвөөс олгох хөрөнгө**

34.1.Халамжийн санд улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг Засгийн газрын саналыг харгалзан Улсын Их Хурал жил бүрийн төсвийн тухай хуулиар тогтооно.

### **35 дугаар зүйл.Халамжийн сангийн тайлан тэнцэл гаргах, тайлагнах**

35.1.Халамжийн сангийн орлого, зарлагын тайланг дор дурдсан хугацаанд гаргаж тайлагнана:

35.1.1.аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага тухайн сарын мэдээг дараа сарын 02-ны, тухайн жилийн эхний хагас жилийн тайланг 7 дугаар сарын 15-ны, жилийн эцсийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн дотор тус тус гаргаж нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

35.1.2.нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тухайн сарын мэдээг дараа сарын 04-ний, тухайн жилийн эхний хагас жилийн тайланг 7 дугаар сарын 25-ны, жилийн эцсийн тайланг дараа оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор гаргаж нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус хүргүүлэх.

35.2.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага халамжийн сангийн жилийн эцсийн нэгдсэн тайлан тэнцлийт хянан хэлэлцэж, дүгнэлт гаргана.

### **36 дугаар зүйл.Халамжийн сангийн мэдээ, тайлангийн маягтын загвар батлах**

36.1.Халамжийн сангийн орлого, зарлагын мэдээ, тайлангийн маягтын загварыг санхүү, төсвийн болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамtran батална.

## **ЗУРГААДУГААР БҮЛЭГ**

### **НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

### **37 дугаар зүйл.Нийгмийн халамжийн удирдлага**

37.1. Нийгмийн халамжийн үйл ажиллагааг улсын хэмжээнд нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, орон нутагт тухайн шатны Засаг дарга тус тусын эрх хэмжээний хүрээнд удирдан зохион байгуулна.

### **38 дугаар зүйл. Нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо, хяналт**

38.1. Нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо нь нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтнаас бүрдэнэ.

38.2. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Засгийн газрын хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий агентлаг байна.

38.3. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргыг Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу нэр дэвшүүлж нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын даргыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцэн нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга тус тус томилж, чөлөөлнө.

38.4. Сумын нийгмийн ажилтныг сумын Засаг даргатай зөвшилцэн аймгийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын дарга, хорооны нийгмийн ажилтныг дүүргийн Засаг даргатай зөвшилцэн дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

38.5. Сум, хорооны нийгмийн ажилтны тоог тухайн засаг захиргааны нэгжийн хүн амын тоо, байршил, нягтралаас хамаарч дараахь байдлаар тогтооно:

38.5.1. сум, тосгоны 3000 хүртэлх хүн ам тутамд нэг нийгмийн ажилтан, нэмэгдэж байгаа 3000 хүн ам тутамд нэг нийгмийн ажилтан нэмж ажиллуулна;

38.5.2. хорооны 5000 хүртэлх хүн ам тутамд нэг нийгмийн ажилтан, нэмэгдэж байгаа 5000 хүн ам тутамд нэг нийгмийн ажилтан нэмж ажиллуулна.

38.6. Нийгмийн халамжийн мэргэжлийн хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9.1-д заасан мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлнэ.

38.7. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь нийгмийн халамжийн үйлчилгээний анхан, дунд шатны байгууллагад мэргэжлийн зөвлөгөө өгөх, нийгмийн халамжийн арга хэмжээний чанар хүртээмж болон халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 38.6-д заасан мэргэжлийн хяналтын байгууллагад хүсэлт гаргах чиг үүрэг бүхий хяналт, шинжилгээ, үнэлгээний нэгжтэй байна.

38.8. Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь энэ хуулийн 38.7-д заасан чиг үүрэг бүхий ажилтантай байна.

### **39 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

39.1.Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан яамны нийтлэг эрхлэх асуудлаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

39.1.1.нийгмийн халамжийн үйл ажиллагааны талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох, хууль тогтоомж, хөтөлбөр боловсруулах, түүний хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах;

39.1.2.улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн нийтлэг зорилтыг тодорхойлоход нийгмийн халамжийн үйл ажиллагааг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаатай уялдуулан иргэдийн амьжиргааг дээшлүүлэх асуудлыг тусгах, салбар хоорондын харилцан хамаарлыг зохицуулах;

39.1.3.яам, нутгийн захиргааны байгууллагын хамтын ажиллагааг нийтлэг зорилтод чиглүүлэх зорилгоор аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулах үр дүнгийн гэрээнд тухайн жилд ядуурлаас гаргах өрх, иргэдийн тоо, мэдээллийг тусгаж гэрээний биелэлтийн явц, үр дүнд хяналт тавих, дүгнэх;

39.1.4.орон нутгийн байгууллага, нийгмийн халамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хувийн өмчтэй байгууллага, аж ахуйн нэгжийн бие даасан байдлыг улс орны хөгжлийн болон иргэдийн нийтлэг ашиг сонирхолтой уялдуулан зохицуулах.

#### **40 дүгээр зүйл.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх**

40.1.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан агентлагийн нийтлэг эрхлэх асуудлаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

40.1.1.нийгмийн халамжийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж нийгмийн халамжийн үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулж, хэрэгжилтийг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор тайлagnах;

40.1.2.энэ хуулийн 32.1.2-32.1.4-д заасан орлогыг бүрдүүлэх зорилгоор хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүр тайлagnах;

40.1.3.нийгмийн халамжийн арга хэмжээг сайжруулах, халамжийн байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар санал боловсруулж нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон эрх бүхий бусад байгууллагад тавих;

40.1.4.доод шатны байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах;

40.1.5.нийгмийн халамжийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, судалгаа, холбогдох бусад баримт бичгийг байгууллага, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах.

40.1.6.нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын талаар мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, тэдгээрт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

40.1.7.олон улсын болон гадаад улсын ижил төрлийн байгууллагатай хамтран ажиллах;

40.1.8.нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, халамжийн байгууллага, ажилтны үйл ажиллагаатай холбоотой иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх;

40.1.9.аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын албан тушаалтны гаргасан хууль бус шийдвэрийг хүчингүй болгох;

40.1.10.зорилтот өрх, иргэний амьжиргааг дэмжих, ядуурлыг бууруулах чиглэлээр батлагдсан үндэсний хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

40.1.11.иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагыг сайн дурын үйл ажиллагаанд уриалах, үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

## **41 дүгээр зүйл.Сум, хорооны нийгмийн халамжийн мэргэжилтэн**

41.1.Нийгмийн ажлын мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш түвшний боловсролтой, нийгмийн ажил, үйлчилгээний чиглэлээр ажиллаж байсан иргэнийг сум, хорооны нийгмийн халамжийн мэргэжилтэн /цаашид “нийгмийн ажилтан” гэх-ээр ажиллуулна.

41.2.Нийгмийн ажилтан нь мэргэжлийн ёс зүйн дүрэмтэй байна. Нийгмийн ажилтанд тавигдах шаардлага, ёс зүйн дүрмийг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

41.3.Энэ хуулийн 41.1 дэх заалт хууль хүчин төгөлдөр болсон хугацаанаас өмнө нийгмийн халамжийн салбарт ажиллаж байгаа нийгмийн ажилтанд хамаарахгүй.

41.4.Нийгмийн ажилтан дор дурдсан үүрэг хүлээнэ:

41.4.1.нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрмийг чандлан сахих;

41.4.2.нийгмийн халамжийн арга хэмжээнд хамрагдсан зорилтот өрх, иргэний судалгаа гаргаж мэдээллийн сан бүрдүүлэх;

41.4.3.нийгмийн халамжийн арга хэмжээнд хамрагдах өрх, иргэний хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлүүлэх;

41.4.4.өрх, иргэнийг амьжиргаагаа дээшлүүлэх чадавхитай болоход нь туслах чиглэлээр зөвлөгөө өгөх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих болон нийгмийн бусад үйлчилгээнд холбон зуучлах;

41.4.5.зорилтот өрх, иргэний амьжиргааг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, гэр бүлийн хөгжлийн чиглэлээр батлагдсан хөтөлбөр, арга хэмжээг орон нутагтаа хэрэгжүүлэх ажлыг бусад салбарын нийгмийн ажилтантай хамтран зохион байгуулах;

41.4.6.иргэнд нийгмийн халамжийн арга хэмжээний зорилт, нөхцөл, болзол болон нийгмийн халамжийн чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын талаар мэдээлэл өгөх;

41.4.7.иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж хамтран ажиллах;

41.4.8.хууль зөрчсөн үйлдлээс бусад тохиолдолд нийгмийн ажилтанд хандсан хувь хүний нууцыг чандлан хадгалах;

41.4.9.хууль тогтоомжид заасан бусад үүргийг хүлээх.

#### 41.5.Нийгмийн ажилтан дор дурдсан эрх эдэлнэ:

41.5.1.нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын үйлчилгээнд хяналт тавих;

41.5.2.энэ хуулийн 41.5.1-д заасан иргэн, байгууллагаас шаардлагатай мэдээ, судалгаа, санхүүгийн тайлан түүнтэй холбоотой баримт, тайлбар, лавлагааг гаргуулан авах;

41.5.3.нийгмийн ажлын чиглэлээр мэргэжлийн мэдлэг, чадвараа дээшлүүлэх, хөгжүүлэх зорилгоор сургалтад хамрагдах;

41.5.4.хууль тогтоомж болон мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл гүйцэтгэхээс татгалзах;

41.5.5.Төрийн албаны тухай хуульд заасны дагуу нийгмийн баталгаагаар хангагдах.

### 42 дугаар зүйл.Аймаг, дүүргийн Нийгмийн халамжийн үйлчилгээний зөвлөл

42.1.Аймаг, дүүргийн Засаг даргын дэргэд энэ хуулийн 22 дугаар зүйлд заасан үйлчилгээг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Нийгмийн халамжийн үйлчилгээний зөвлөл /цаашид “зөвлөл” гэнэ/ ажиллана.

42.2.Зөвлөл нь 9 гишүүнээс бүрдэх бөгөөд зөвлөлийн дарга нь тухайн аймаг, дүүргийн Засаг дарга, нарийн бичгийн дарга нь тухайн шатны нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын дарга байна. Зөвлөлийн гишүүнд тухайн орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, аж ахуй нэгж байгууллага, судлаачийн төлөөллийг оруулна.

42.3.Зөвлөл нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

42.3.1.тухайн жилд орон нутагт хэрэгжүүлэх олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээний төлөвлөгөөг батлах;

42.3.2.энэ хуулийн 42.3.1-д заасан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийн төслийг хэлэлцэн саналаа тусгах, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулах;

42.3.3.тухайн орон нутагт олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагыг энэ хуулийн 29.2-т заасан шалгуур, нөхцлийн дагуу сонгон шалгаруулах;

42.3.4.энэ хуулийн 42.3.3-д заасан иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээний тайланг жил бүр Зөвлөлийн хурлаар хэлэлцэж дүгнэлт өгөх, дараа жилд хэрэгжүүлэх арга хэмжээний санал зөвлөмж гаргах;

42.3.5.олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээний талаар иргэд, байгууллагаас гарсан гомдол саналыг хэлэлцэж шийдвэрлэх;

42.3.6.үйлчилгээ үзүүлэгч байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, дүгнэлт гаргах, иргэний эрх ашгийг хохироосон бол тухайн байгууллагын гэрээг цуцлах талаарх саналыг холбогдох байгууллагад гаргах.

42.4.Зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа 3 жил байх бөгөөд бүрэлдэхүүнийг аймаг, дүүргийн Засаг дарга батална.

42.5.Зөвлөлийн дүрэм болон гишүүдэд улирал бүр олгох урамшууллын хэмжээг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

42.6.Энэ хуулийн 42.5-д заасан урамшууллын зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

42.7.Зөвлөлийн үйл ажиллагаанд тухайн шатны Иргэдийн Төлөөллөгчдийн хурал хяналт тавьж ажиллана.

### **43 дугаар зүйл.Сум, хорооны Амьжирагааг дэмжих зөвлөл**

43.1.Иргэнийг энэ хуулийн 7.1.7, 8.1.2, 12.1.1-12.1.3 заасан нийгмийн халамжийн арга хэмжээнд хамруулах эсэх талаар дүгнэлт гаргах, халамжийн үйл ажиллагаатай холбогдсон санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх чиг үүрэг бүхий Амьжирагааг дэмжих орон тооны бус зөвлөл /цаашид “зөвлөл” гэх/ сум, хороонд ажиллана.

43.2.Зөвлөлийн бүрэлдэхүүнийг сум, хорооны Засаг даргын санал болгосноор сум, хороонд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж батална.

43.3.Зөвлөл нь 7 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд дараах төлөөллөөс бүрдэнэ:

- 43.3.1.нийгмийн ажилтан 1 хүн;
- 43.3.2.төрийн байгууллагын төлөөлөл 2 хүн;
- 43.3.3.төрийн бус байгууллагын төлөөлөл 2 хүн;
- 43.3.4.иргэний төлөөлөл 2 хүн.

43.4.Зөвлөлийн гишүүнд сум, хорооны Засаг дарга нэрээ дэвшүүлэхийг хориглоно.

43.5.Энэ хуулийн 43.3.3, 43.3.4-т заасан Зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 2 жил байх бөгөөд гишүүнийг нэг удаа улируулан сонгож болно.

43.6.Зөвлөлийн үйл ажиллагаанд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, иргэдийн Нийтийн Хурал, аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллага хяналт тавьж ажиллана.

43.7.Зөвлөлийн шийдвэр нь Хувь хүний нууцын тухай хуульд<sup>6</sup> зааснаас бусад тохиолдолд олон нийтэд нээлттэй, ил тод байна.

43.8.2000-аас дээш хүн амтай баг, тосгонд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр Зөвлөл ажиллуулж болно.

43.9.Зөвлөлийн гишүүдэд ажлын оролцоо, идэвх чармайлтыг харгалзан улиралд нэг удаа урамшуулалт олгоно.

43.10.Зөвлөлийн дүрэм болон гишүүдэд олгох урамшууллын хэмжээг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

43.11.Зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой гарах зардал, гишүүдэд олгох урамшууллыг халамжийн сангаас санхүүжүүлнэ.

## ДОЛДУГААР БҮЛЭГ

### ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

#### 44 дүгээр зүйл.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг

44.1.Нийгмийн халамжийн арга хэмжээнд хамрагдаж байгаа өрх, иргэн дараах үүргийг хүлээнэ:

44.1.1.өрхөд шинээр хүүхэд төрсөн, үрчлэн авсан, өрхийн гишүүн нас барсан эсхүл шилжиж ам булийн тоонд өөрчлөлт орсон бол сум, хорооны нийгмийн ажилтанд 14 хоногийн дотор мэдэгдэх;

44.1.2.нийгмийн халамжийн арга хэмжээнд хамрагдахаа энэ хуульд заасан нөхцөл, шалгуурыг биелүүлэх;

<sup>6</sup>Хувь хүний нууцын тухай хууль -“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1995 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

44.1.3. орон нутгаас зохион байгуулах нийтийг хамарсан үйл ажиллагаанд идэвх, санаачилгатай оролцох.

44.2. Иргэн нь нийгмийн халамжийн арга хэмжээнд хамрагдах шаардлагатай зорилтот өрх, иргэний талаар тухайн орон нутгийн нийгмийн халамжийн байгууллага, нийгмийн ажилтан, нутгийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

44.3. Иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь нийгмийн хариуцлагын хүрээнд зорилтот өрх, иргэнд чиглэсэн сайн дурын үйл ажиллагаа зохион байгуулж дэмжлэг үзүүлнэ.

44.4. Төрийн захиргааны төв байгууллага нь энэ хууль болон эрхэлсэн асуудлынхаа хүрээнд зорилтот өрх, иргэнд чиглэсэн төсөл, хөтөлбөр боловсруулж нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамtran хэрэгжүүлнэ.

#### **45 дугаар зүйл. Бүх шатны Засаг дарга нарын хүлээх үүрэг**

45.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь энэ хуулийн 39.1.3-т заасны дагуу орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан ядуурлыг бууруулах зорилтыг хэрэгжүүлж, биелэлтийг хангаж ажиллана.

45.2. Орон нутгийн ядуурлыг бууруулах зорилтыг хэрэгжүүлэхэд иргэн, аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллагын оролцоо, санал санаачилгыг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулж хамtran ажиллана.

45.3. Сум, дүүргийн Засаг дарга нь энэ хуулийн 45.1-т заасан арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагаас зохион байгуулах төсөл, хөтөлбөр нийгмийн бусад үйлчилгээнд зорилтот өрх, иргэнийг тэргүүн ээлжид хамруулна.

45.4. Баг, хорооны Засаг дарга нь зорилтот өрх, иргэнийг нийгмийн халамжийн болон нийгмийн бусад үйлчилгээнд хамрагдахад дэмжлэг үзүүлнэ.

#### **НАЙМДУГААР БҮЛЭГ НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН НЭГДСЭН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЭЛ**

#### **46 дугаар зүйл. Нийгмийн халамжийн нэгдсэн бүртгэл, мэдээлэл**

46.1. Нийгмийн халамжийн нэгдсэн бүртгэл, мэдээлэл нь дараах мэдээллийн сангаас бүрдэнэ.

- 46.1.1. нийгмийн халамжийн мэдээллийн сан;
- 46.1.2. өрхийн мэдээллийн нэгдсэн сан.

46.2. Нийгмийн халамжийн мэдээллийн сан нь нийгмийн халамжийн арга хэмжээнд хамрагдаж байгаа иргэдийн тоо, зарцуулсан хөрөнгө болон бусад мэдээллээс бүрдэнэ.

46.3. Өрхийн мэдээллийн нэгдсэн сан нь Үндэсний статистикийн хороо болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хамtran баталсан өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалын дагуу

Монгол Улсын нийт өрх, хүн амыг амьжиргааны түвшингээр нь эрэмбэлсэн мэдээллээс бүрдэнэ.

46.4.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь мэдээлийн санг бүрдүүлэх, хэвийн ажиллуулах, шинэчлэх үүрэг хүлээнэ.

46.5.Мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, түүний аюулгүй байдлыг хангах журмыг Засгийн газар батална.

46.6.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь мэдээллийн сангийн тоо баримт, тайланг Үндэсний статистикийн хороо, Монгол банк, төрийн захиргааны төв байгууллагатай үнэ төлбөргүй солилцож, харилцан мэдээлнэ.

#### **47 дугаар зүйл.Нийгмийн халамжийн статистик мэдээлэл**

47.1.Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь нийгмийн халамжийн тухайн сарын статистик мэдээллийг дараа сарын 03-ны өдрийн дотор, тухайн жилийн эхний хагас жилийн мэдээг 8 дугаар сарын 08-ны дотор, жилийн эцсийн мэдээг дараа оны 3 дугаар сарын 08-ны дотор нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

47.2.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь нийгмийн халамжийн тухайн сарын статистик мэдээллийг дараа сарын 06-ны өдрийн дотор, тухайн жилийн эхний хагас жилийн мэдээг 8 дугаар сарын 15-ны дотор, жилийн эцсийн мэдээг дараа оны 3 дугаар сарын 15-ны дотор Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон Үндэсний статистикийн хороонд хүргүүлнэ.

47.3.Нийгмийн халамжийн статистик мэдээний маягтыг Үндэсний статистикийн хороо болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

#### **ЕСДҮГЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

#### **48 дугаар зүйл.Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг зогсоох, түүнээс суутгал хийх**

48.1.Тэтгэвэр, тэтгэмж авагч хуурамч баримт бичиг бүрдүүлж тэтгэвэр, тэтгэмж тогтоолгон авсан нь тогтоогдвол уг тэтгэвэр, тэтгэмжийн олголтыг зогсооно.

48.2.Тэтгэвэр, тэтгэмж авагч хуурамч баримт бичиг бүрдүүлсний улмаас илүү олгогдсон тэтгэвэр, тэтгэмжийг нөхөн төлүүлэх тухай шүүхийн шийдвэр, эсхүл улсын байцаагчийн шийдвэр гарсан бол суутгал хийж болно.

48.3.Энэ хуулийн 48.2-т заасан суутгалын хэмжээ нь сарын тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээний 50 хувиас хэтэрч болохгүй.

48.4.Энэ хуулийн 48.2-т зааснаас бусад тохиолдолд тэтгэвэр, тэтгэмжээс сүүтгал хийхийг хориглоно.

48.5.Нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, ажилтны гаргасан алдааны улмаас илүү олгогдсон тэтгэвэр, тэтгэмжийг буцаан суутгахгүй бөгөөд хохирлыг шүүхийн журмаар буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ.

48.6.Энэ хуулийн 44.1.1-д заасан үүргээ биелүүлээгүй улмаас илүү авсан тэтгэвэр, тэтгэмжийг иргэнээр нөхөн төлүүлнэ.

#### **49 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

49.1.Энэ хуулийг зөрчсөн төрийн албан хаагчийн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

49.2.Энэ хуулийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

#### **50 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

50.1.Энэ хуулийг 20.....оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

201... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2019 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

201... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**2010 оны 6 дугаар сарын 25-ны өдөр баталсан Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2019 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

201... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтын “...байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх...” гэсний өмнө “...амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур...” гэж, 26.1.2, 26.1.3 дахь заалтын “дотоодод хийлгэсэн” гэсний дараа, “Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.6, 9.1.8-д зааснаас бусад” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“26.4.Энэ хуулийн 26.1, 33.4 дэх хэсэгт заасан тусламж, хөнгөлөлтийн хэмжээ, олгох журам, жишиг үнийг Засгийн газар батална.

**3 дугаар зүйл.**Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1.6, 26.1.14, 26.1.16 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1.1 дүгээр заалтын “...ариун цэвэр-эрүүл ахуйн материал, ...” гэснийг тус тус хассугай.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

201... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### АХМАД НАСТНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Ахмад настны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.1.3 дахь заалтын "...ахмад.." гэсний өмнө, 8.1.3 дахь заалтын "...хүндэт донор..." гэсний дараа "...амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур амьжиргаатай..." гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Ахмад настны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын доор дурьдсанаар өөрчлөн найруулсугай.

"10.1.2.эмчилгээ, сувилгаа зайлшгүй шаардлагатай ахмад настан болон хүндэт донор ахмад настан өмнэлгийн байгууллагын дүгнэлтээр магадлан итгэмжлэгдсэн дотоодын раашан сувилалд амарч сувилуулах тохиолдолд тээврийн хэрэгслийн нэг талын зардал, эрхийн бичгийн үнийн хөнгөлөлт үзүүлэх;".

**3 дугаар зүйл.**Ахмад настны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын "хөл, гарны протез, сонсох, харах эрхтний ортопедийн хэрэгсэл, тэргэнцэр" гэснийг "зарим төрлийн протез, ортопедийн болон тусгай хэрэгслийг" гэж, 7 дугаар зүйлийн 7.2.7 дугаар заалтын "...19..." гэснийг "...30..." гэж, 7.2.8 дугаар заалтын "...22.1.1..." гэснийг "...12.1.2..." гэж, 7.3 дугаар хэсгийн "...18.8..." гэснийг "...29.2..." гэж, 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь хэсгийн "...13.6..." гэснийг "...8.2.3..." гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дүгээр хэсгийн "...27..." гэснийг "...43..." гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

201... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### АЛДАР ЦОЛТОН АХМАД НАСТАНД ТӨРӨӨС НЭМЭГДЭЛ, ХӨНГӨЛӨЛТ ОЛГОХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтад дор дурдсан 8.1.1 гэсэн дэд заалт нэмсүгэй:

“8.1.1. Энэ хуулийн 5.3.1, 5.3.3-д заасан мөнгөн тусламжийг энэхүү хууль батлагдахаас өмнө эрх нь үүссэн алдар цолтон ахмад настанд харьяалах төрийн захиргааны төв байгууллага, 5.3.2-д заасан ахмад дайчинд нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, хууль хэрэгжих эхэлсэн хугацаанаас шинээр алдар цолтон болсон ахмад настанд нэг удаа олгох нэмэгдлийг Ерөнхийлөгчийн Тамгын газраас олгоно.

**2 дугаар зүйл.** Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.5 дахь хэсгийн “нэмэгдэл” гэсний өмнө “Энэ хуулийн 5.3.2, 5.4.1, 5.4.2-д заасан” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.3 дахь заалтыг хассугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

201... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ЭХ, ОЛОН ХҮҮХЭДТЭЙ ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭХ, ЭЦЭГТ ТЭТГЭМЖ ОЛГОХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн нэрийн "...Эх,...” гэсний дараа "...хүүхэд,...” гэж нэмсүгэй.

**2.дугаар зүйл.** Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд дор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 3 дугаар зүйлийн 1.5 дахь заалт:

“3.1.5.“Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эх” гэж дөрвөн хүүхэд төрүүлж өсгөсөн, “Эхийн алдар” хоёрдугаар зэргийн одонгоор шагнагдсан эх, болов түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн, “Эхийн алдар” нэгдүгээр зэргийн одонгоор шагнагдсан эхийг.”

2/ 5 дугаар зүйлийн 5.1.5, 5.1.6 дахь заалт:

“5.1.5.Хүүхдийн мөнгөн тэтгэмж;

5.1.6.Эхийн алдар” нэгдүгээр зэргийн одон, эсхүл “Эхийн алдар” хоёрдугаар зэргийн одонтой эхийн мөнгөн тэтгэмж.”

3/ 6 дугаар зүйлийн 6.5, 6.6 дахь хэсэг:

“6.5.Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.12-д заасан босго онооноос доогуур амьжиргаатай өрхийн 0-18 насны хүүхэд сар бүр тэтгэмж авах эрхтэй.

6.6.энэ хуулийн 3.1.5-д заасан нөхцөлийг хангасан эх жилд нэг удаа давхардуулахгүйгээр мөнгөн тэтгэмж авах эрхтэй.”

4/ 7 дугаар зүйлийн 7.6, 7.7, 7.8 дахь хэсэг:


“7.6.Энэ хуулийн 3.1.5-д заасан “олон хүүхэд төрүүлж өсгөсөн” гэдэгт бага хүүхэд нь нэг нас хүрэхэд дөрөв, эсхүл 6 ба түүнээс дээш хүүхэдтэй байсан бөгөөд үүнд гурав хүртэлх насанд нь үрчлэн авсан хүүхэд хамаарна. Харин тухайн эхийн төрүүлж бусдад үрчлүүлсэн хүүхэд хүүхдийн тоонд хамаарахгүй.

7.7. Энэ хууль хэрэгжиж эхэлсэн хугацаанаас шинээр “Эхийн алдар” одонг авах эрх нь үүссэн эхэд 0-18 хүртэлх насны хүүхдийн тооноос хамааруулан тэтгэмжийн хэмжээг ялгаатай тогтооно.

7.8. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь орон сууц барих аж ахуйн нэгжийн удирдлагатай тохиролцон шинээр баригдах орон сууцны дэд бүтцэд төсвөөс оруулсан хөрөнгө оруулалттай тэнцэх хэмжээний үнийн дүнтэй орон сууцыг эзэмшилдээ авах, эхний ээлжид орон байргүй олон хүүхэдтэй гэр бүлд хөлслүүлэх, төлбөрийн уян хатан, хөнгөлөлттэй нөхцөлөөр худалдан авах боломж бүрдүүлнэ.”

**3 дугаар зүйл.** Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “...зорилт...” гэсний дараа “...0-18 насны хүүхэд, олон хүүхэд төрүүлж өсгөсөн эх,...” гэж, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “...5.1.3...” гэсний дараа “5.1.5, 5.1.6” гэж, 7.3 дахь хэсгийн “...санхүүжүүлнэ...” гэсний дараа “...“Эхийн алдар” нэгдүгээр болон хоёрдугаар зэргийн одонг дагалдах мөнгөн шагналыг Ерөнхийлөгчийн Тамгын газраас олгоно...” гэж тус тус нэмсүгэй.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.



Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

201... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт дор дурдсан 4.2.6 дугаар заалт, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт 30.1.17<sup>1</sup> хэсгийг тус тус нэмсүгэй:

“4.2.6.нийгийн халамжийн арга хэмжээг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаатай уялдуулан иргэдийг амьжиргааг дээшлүүлэх.”

“30.1.17<sup>1</sup> хөдөлмөр эрхлэлтийн болон нийгмийн халамжийн байгууллагын хамтын үйл ажиллагааг иргэдийн амьжиргааг дээшлүүлэх нийтлэг зорилтыг хэрэгжүүлэхэд чиглүүлэх талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх;”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

201... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Гэр бүлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөсүгэй:

“5.2.Төрийн захиргааны болон нийгмийн халамжийн байгууллага нь гэр бүлийн гишүүн нийгмийн, санхүүгийн, сэтгэл зүйн болон эрүүл мэндийн бэрхшээлээ даван иргэний эрхээ эдлэх, үүргээ биелүүлэхэд туслах үүрэг хүлээнэ.”

**2 дугаар зүйл.**Гэр бүлийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.3 дахь хэсгийн “...урамшуулал...” гэснийг “...амьжиргааны тусламж...” гэж, мөн зүйлийн 74.7 дахь хэсгийн “...урамшуулалд...” гэснийг “...амьжиргааны тусламжид...” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

201... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 40 дүгээр зүйл, 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтын "...40...", 21 дүгээр зүйлийн 21.1.1 дэх заалтын "...40..." гэснийг тус тус хассугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

201... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### НЯЛХ, БАЛЧИР ХҮҮХДИЙН ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн "...22 дугаар..." гэснийг "...14..." гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

201... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийн "...20.2-т заасан..." гэснийг "...3.1.3-т заасан өрх, иргэний хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, бүтэн ба хагас өнчин хүүхэд, орон гэргүй тэнэмэл амьдралтай иргэний..." гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

201... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрүүгийн хуулийн 18.12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ, нийгмийн хөгжлийн үйлчилгээг авсан” гэснийг “нийгмийн халамжийн арга хэмжээнд хамрагдсан” гэж, 2.2 дахь хэсгийн “нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ, нийгмийн хөгжлийн үйлчилгээг авч” гэснийг “нийгмийн халамжийн арга хэмжээнд хамрагдаж” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

201... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хувь хүний орлогын албан татварын тухай 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

“16.1.17. 0-18 наасны 4 ба түүнээс дээш тооны хүүхэдтэй эхийн /хэрэв эх нь нас барсан бол төрүүлсэн эцэг, хууль ёсны асран хамгаалагчийн/ олсон 40 сая төгрөгнөөс дээшгүй орлого.”

**2 дугаар зүйл.** Хувь хүний орлогын албан татварын тухай 26 дугаар зүйлийн 26.1.5 дахь заалтын “16.1.12” гэсний дараа “16.1.17” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## ГАРЫН ҮСЭГ

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны... дугаар сарын  
...ны өдөр

Улаанбаатар хот

### ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хүүхэд хамгааллын тухай хуулийн 13 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай заалтыг тус тус нэмсүгэй.

“13.5.Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, магадлан итгэмжлэх журам, сургалтын хөтөлбөрийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

“13.6.Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний хоол хүнс, хувцас, зөвлөн эдлэл, эм, ариун цэвэр, сургалтын хэрэглэгдэхүүний зардлын хэмжээг санхүү, төсвийн болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.”

“13.7.Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний төсвийг батлуулах, зарцуулах, үйл ажиллагаанд хяналт тавих журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

**2 дугаар зүйл.**Хүүхэд хамгааллын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийг доор дурьдсан агуулгаар өөрчлөн найруулсугай.

“13.4.Аймаг, дүүргийн Засаг дарга эрдэлт нөхцөлд байгаа хүүхдийг хувилбарт үйлчилгээнд хамруулах тухай шийдвэрийг хамтарсан баг, нийгмийн ажилтны санал, дүгнэлтийг үндэслэн гаргаж, шийдвэрийн хэрэгжилтэд хүүхдийн эрхийн ажилтан хяналт тавина.”

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

201... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар  
 хот

### Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТӨГТООХ нь:

1. Нийгмийн халамжийн тухай хуулийг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай:

1/ хууль хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, хуульд заасан захиргааны хэм хэмжээний актыг 2019 оны 12 дугаар сарын 31-ний дотор батлах;

2/ хүн амд нийгмийн халамжийн арга хэмжээг хүргэх нийгмийн ажилтныг хуульд заасан нормативын дагуу ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авах, шинээр нэмэгдэх орон тооны талаар санаалаа боловсруулж Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуулийн төсөлд тусгах;

3/ хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор бүх шатны Засаг дарга, нийгмийн халамж, хөдөлмөрийн ажилтнуудын сургалт, семинарыг бүсчилэн зохион байгуулах, гарын авлага, аргачлалаар хангах;

4/ Нийгмийн халамжийн тухай хуулийг дагалдан Ахмад настны тухай, Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан хууль хэрэгжиж эхэлсэн хугацаанаас шинээр алдар цолтон болсон ахмад настанд нэг удаа олгох нэмэгдэл, “Эхийн алдар” нэгдүгээр болон хоёрдугаар зэргийн одонг дагалдах мөнгөн шагналд шаардагдах хөрөнгийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн төсөвт 2020 оноос эхлэн тусгах;

5/ Алдар цолтон ахмад настанд нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулийн 5.3.1, 5.3.3-д заасан алдар цолтон ахмад настнуудын мэдээлэл, холбогдох баримт бичгийг харьяалах төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлэх, эдгээр мэдээлэлд тулгуурлан шаардагдах хөрөнгийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт тусгах;

6/ Нийгмийн халамжийн тухай хуулийг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах, түүнтэй холбоотой нэмэлт зардлыг санхүүжүүлэх.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо /Ё.Баатарбилэг/-нд үүрэг болгосугай.

### ГАРЫН ҮСЭГ